



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 17 өдөр


Дугаар 02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02-р сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн 2022 оны ногдол ашгийг татвар төлсний дараахь цэвэр ашгаас хуваарилж олгосугай.
2. Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 2000 төгрөгийн ногдол ашиг олгохоор тогтоосугай.
3. Компанийн ногдол ашиг авах эрхтэй Хувьцаа эзэмшигчдийг 2023 оны 03-р сарын 09-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
4. Ногдол ашгийг 2023 оны 04-р сарын 14-ний өдрөөс эхлэн компани дээрээс олгосугай.
5. Дээрх хугацаанд аваагүй ногдол ашгийн үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн ҮЦТХТ ХХК-д байрлах дансанд байршуулахаар шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу ногдол ашиг олгохыг Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэг, Бизнес хөгжил, санхүү хариуцсан захирал С.Дашдулам нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ЫН ДАРГА  Т.ТУНГАЛАГ





**ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г

Г

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэхь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.1 дэхь заалт, Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02-р сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн

“Техник импорт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02-р сарын 15-ны өдрийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2023 оны 04-р сарын 14-ний өдрийн 16 00 цагт Баянгол дүүрэг, 5 р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125, Техник импорт ХК-ийн “Хурлын танхим”-д хуралдуулсугай.
2. Техник импорт ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
  - 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
  - 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
  - 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
  - 2023 оны компанийн бүтэц, зохион байгуулалт
  - 2023 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс 2023 оны 03 сарын 09-ний өдөр ( бүртгэх өдөр)-өөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн тогтоосугай.
4. “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.5-д заасны дагуу бүртгэлийн өдрийг 2023 оны 03-р сарын 09-ний өдрөөр тасалбар болгохоор тогтоосугай.



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ өдөр

Дугаар \_\_\_\_\_

Улаанбаатар хот

5. Компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2023 оны 04-р сарын 14-ний өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн хурлын зар /Хавералт1/-ыг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хурлыг зохих журмын дагуу явуулахыг Хурал зохион байгуулах комиссын дарга О.Бүжинлхамд даалгасугай.
7. 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Дандондог овогтой Гингэнгэгийг томилсугай
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.  
Тооллогын комиссын дарга Д.Пүрэвсүрэн  
Тооллогын комиссын гишүүн Д.Монхтуяа
9. Компанийн тухай хуулийн 67.3, 67.4-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлж санал уралагтын дүнг үнэн, зөв гаргаж хариуцлагатай ажиллахыг Тооллогын комисст үүрэг болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавералт2-т заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 04-р сарын 13-ны өдрийн 18 цагаар тасалбар болгосугай.
12. Хурал хуралдуулах шийдвэрийг гаргаснаас хойш ажлын 3 хоногийн дотор Техник импорт ХК-ийн ТУЗ-ын хурлын тэмдэгтэд, тогтоол, хавералт материалууд, СЗХ-ноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл” маягтын хамт СЗХ, Монголын Хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисст даалгахаар тогтоосугай.

ТУЗ-ЫН ДАРГА  Т.ТУНГАЛАГ

